

ӨСВӨР ҮЕ ХҮНС

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ /1980-2012 он/

АРХИВЫН ШИФР

Хөмрөгийн дугаар	192
Дансны дугаар	1
Байнга хадгалах баримтын тоо	79ХН
Баримтын оны хязгаар	1981-2006

БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Дээд газрын шийдвэр, огноо	Нэрийн өөрчлөлт
1	1980 оны 07 дугаар сарын Ардын боловсролын яам, Сангийн яамны шийдвэр	Ажилчны районы сургууль цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуйн төв
2	УБ хотын Ажилчны районы АХГЗ-ны 1992 оны 07 дугаар сарын 31-ний 53 дугаар тогтоол	“Цагаан лавай” компани
3	ХУД-ийн Засаг даргын 2001 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар захирамж	Хан-Уул хангамж
4	НИТХТ-дийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний 154 дүгээр тогтоол	Өсвөр үе –Хүнс НӨҮГ

НЭГ. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН ТҮҮХ

1965 онд Улаанбаатар хотын хороодод шинэчилсэн зохион байгуулалт хийж хотын таван район байгуулж, дээрх районуудын АДХГЗ-ны дэргэд Боловсролын хэлтэс байгуулагдаж УБ хотын АДХГЗ-ны дэргэдэх Гэгээрлийн хэлтсийн харъяалалд ажиллаж байсан сургууль, цэцэрлэгүүдийн нягтлангуудыг райодын Боловсролын хэлтэст шилжүүлснээр район бүрт 6-8 нягтлантай, сантехникийн ажил хариуцсан 1 механик, цахилгаан шугам сүлжээ хариуцсан дунд мэргэжлийн монтёр нэгтэйгээр тус тус ажиллаж эхэлцгээсэн байна.

Нийслэл хот жилээс жилд хот төлөвлөлтийн дагуу өргөжин тэлж, хүн амын төвлөрөл улам нэмэгдэж, сургууль цэцэрлэгүүд олноор бий болж, ачаалал эрс нэмэгдэн тэдний өдөр тутмын санхүү аж ахуйг удирдахад төвөгтэй болж ирсэн тул 1970 оны үед байгуулагдсан Санхүү аж ахуйн тасгийг өргөтгөн бүх районуудын Боловсролын хэлтсүүдийн дэргэд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1979 оны 389 дүгээр тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХГЗахиргаа, Ардын Боловсролын Яам, Сангийн Яамны шийдвэрээр 1980 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс Сургууль, цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуйн төвүүд байгуулагдсан байна. Дээрх аж ахуйн төвүүд нь район бүрт өөр өөрийн бие даасан байр, агуулах складтай, цэцэрлэг, сургууль бүрт өдөр тутам хэрэглэгдэх хүнсний материалаас гадна ариун цэврийн хэрэглэл материал, бичгийн хэрэглэл, засвар үйлчилгээний хэрэглэгдэхүүн зэрэг тэдэнд шаардагдах бүхий л хэрэглэл материалаар хангаж, анхан шатны тооцоо, тоо бүртгэлийг гардан хариуцдаг төв байхаар зохион байгуулагдан ажиллаж ирсэн байна.

Аж ахуйн төвүүд нь дарга, ахлах нягтлан 1, тооцооны нягтлан 8, аж ахуйн нярав 6, кассын нярав 1, түгээгч нярав 4, жолооч 2, үйлчлэгч 3, бичээч 1, манаач 3, слесарь 2 зэрэг гуч гаруй ажиллагсадтайгаар тус бүрдээ гуч орчим байгууллагад өдөр тутам шаардагдах хэрэгцээт материал хүргэж өгөхөөс гадна цэцэрлэг, сургуулиудын нийт ажилтан албан хаагчдын цалингийн тооцоог хүртэл төвлөрүүлэн бодож олгох ажлыг хариуцдаг байв.

Ийм зохион байгуулалтанд орж ажилласнаар сургууль, цэцэрлэгт ажиллаж байсан нягтлан, морь тэрэгчин, слесарь зэрэг олон орон тоо цомхотгогдож, 1980-аад оны үеийн ханшаар жилдээ

цалингийн фонд гурван зуу гаруй мянган төгрөгөөр хэмнэгдэж байсан байна.

1990 оноос улс орон даяар их өөрчлөн байгуулалт явагдаж түүний үр нөлөөгөөр Үндсэн хууль өөрчлөгдөж, түүнд нийцсэн “Аж ахуйн нэгж компанийн тухай” шинэ хууль гарснаар нэгдсэн аж ахуйн төвүүд бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж, компанийн зохион байгуулалтаар ажиллах болсон билээ. Ингээд дүүрэг бүрийн дэргэд ажиллаж байсан цэцэрлэг, сургуулиудын нэгдсэн аж ахуйн төвүүд татан буугдаж, дүүрэг бүрийн Засаг даргын захирамжаар тус бүрдээ “Бүрэн бус хариуцлагатай компани”-ууд байгуулагдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар компанийн захиралуудыг тус бүрд нь томилсон байна. Ингээд 1992 оны 06 дугаар сард Хан-Уул дүүргийн засаг даргын захирамжаар нэгдсэн аж ахуйн төв татан буугдаж, түүний суурин дээр “ЦАГААН-ЛАВАЙ” ББХК байгуулагдаж захирлаар нь тус дүүргийн 15 дугаар сургуульд захирлаар ажиллаж байсан н.Мягмар томилогдсон байна. Зах зээлийн ороо бусгаа хүндрэлтэй 1993-1994 онуудад цэцэрлэгүүдийн хүнсний хангамж зогсонги байсныг дахин зохион байгуулж, харьяа 40 гаруй байгууллагуудын төсөвт болон урсгал засварын ажлуудыг хариуцан гүйцэтгэж байжээ.

Н.Мягмарын дараа тус компанийн захирлаар 1995-2002 онд П.Ганбаатар, “Хан- Уул хангамж” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар 2002-2005 онд Уртнасан, 2005-2006 онд Ц.Одонтунгалаг нар захирлаар ажилласан байна.

Мөн 1992 оны 06 дугаар сард Баянзүрх дүүргийн Засаг даргын захирамжаар тус дүүргийн нэгдсэн аж ахуйн төв татан буугдаж, түүний хөрөнгө суурин дээр мөн дүүргийн Засаг даргын захирамжаар “БАЛЧИРХАН” ББХК байгуулагдаж захиралаар нь тус дүүргийн 8 дугаар сургуульд захирлаар ажиллаж байсан Д.Баттөмөр томилогдож 2006 оны 07 дугаар сар хүртэл ажилласан байна.

Дээрх компаниудын үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж хөрөнгө санхүү эргэлтийн хөрөнгийн хувьд томоохон өөрчлөлт гарч түүнтэй холбогдох хуулиудад зохих өөрчлөлтүүд орсноор 1997 оноос компаниудын харьяалал, өмч хөрөнгө нийслэлийн өмчид бүртгэгдэх болсноор Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болсон түүхтэй.

1997 оноос хотын хөрөнгө оруулалт мөн дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 14 цэцэрлэг, сургуулиудын их засварын ажлыг нэгдсэн бригад засварчдынхаа хүчээр бие даан хийж нийтдээ 18 мянга гаруй хүүхэд багачууд сурч хүмүүжиж буй 1000 гаруй багш, ажилчдын ая тухтай сурч хүмүүжих орчинг бүрдүүлж ажилласан.

1999 онд Туул тосгоны 144 цэцэрлэг 26 сургуульд халаалтын бага оврын зуух угсран монтажлаж, тус компанийн цахилгаан сантехникчдийн мэргэжлийг дээшлүүлэхийн тулд дүүргийн хөдөлмөрийн биржтэй хамтран курс зохион байгуулж, дулааны шугам сүлжээний газраас багш нарыг урин хичээл сургалт явуулан мэргэжлийн үнэмлэх шинэчлэн солих ажлыг жил тутам зохион байгуулж байна. Тус байгууллага нь өнөөгийн зах зээлийн нөхцөлд зохицуулан харьяа газруудыг гэрээлэн авч, засвар үйлчилгээ явуулж, орон тоо цалингийн фондоо батлуулж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, бизнес төлөвлөгөө боловсруулан ажиллаж иржээ.

Иймээс дээрх үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг захиран зарцуулах ерөнхий эрх нь Нийслэлийн Иргэдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад шилжсэн байна. Ингэснээр дээрх компаниудын үйл ажиллагааг өргөтгөх, хариуцлагыг төвлөрүүлэх зорилгоор 2006 оны 06 дугаар сард Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 154 дүгээр тогтоолоор дүүрэг бүрийн дэргэдэх “БАЛЧИРХАН”, “ХАН- УУЛ Хангамж”, УҮГ-уудыг татан буулгаж, тэдгээрийн суурин дээр дээрх тогтоолоор “ӨСВӨР ҮЕ-ХҮНС” нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг байгуулсан түүхтэй юм. Ингээд 2006 оны 07 дугаар сараас тус үйлдвэрийн газрын захирлаар Ц.Дангаасүрэн томилогдон 2010 оны 12 дугаар сар хүртэл ажилласан байна.

2011 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 44 дүгээр захирамжаар тус нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Ц.Амарсанаа томилогдон ажиллаж байна.

“ӨСВӨР ҮЕ-ХҮНС” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь 2006 оноос захирал, ерөнхий нягтлан, тооцооны нягтлан, менежер, эрүүл ахуйч эмч, нярав, үйлчлэгч, жолооч зэрэг 14 ажилтантайгаар Баянзүрх, Хан-Уул дүүргийн 45 цэцэрлэгт хүмүүжиж байгаа 9000 гаруй хүүхэд, багачуудад өдөр тутмын хэрэгцээт хоол хүнсний материал тасралтгүй хүргэж, үйлчлэх үндсэн үүрэгтэйгээр ажлаа хэвийн явуулж байна.

2011 оны байдлаар захирал, ерөнхий нягтлан, тооцооны нягтлан, менежер, эрүүл ахуйч эмч, нярав, үйлчлэгч, жолооч, ачигч зэрэг 16 ажилтантайгаар Баянзүрх дүүргийн 29 дүгээр цэцэрлэг Хан-Уул дүүргийн 21 дүгээр цэцэрлэг, Багахангай дүүргийн 1 дүгээр цэцэрлэг нийт 51 дүгээр

цэцэрлэгийн 15000 орчим хүүхэд багачуудыг өдөр тутмын хэрэгцээт хоол хүнсийг ханган ажиллаж байна.

Санхүүгийн алба үүсч байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Баянзүрх дүүргийн бүх албан газрын дунд зохион байгуулагдсан сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож дэд байр эзлэн өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан.

Мөн 2011 онд Хан-Уул дүүргийн “Шилдэг татвар төлөгч” байгууллагаар шалгаран өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан .

ХОЁР. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Тус Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн Газрыг байгуулагдахад татан буугдсан “Балчирхан” компани нь өөрт холбогдох бүх бичиг баримтыг Нийслэлийн Архивын газар хүлээлгэн өгсөн байсан.

Харин “Хан-Уул хангамж” компанийн архивын баримт нь эмх цэгцгүй байсан бөгөөд “Өсвөр-Үе хүнс” НӨҮГ-аас 2008 оны 03 дугаар сард Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгсөн.

“Хан-Уул хангамж” компанийн баримтанд Нийслэлийн архивын газрын архивч Н.Амархүү эрдэм шинжилгээ боловсруулалтын ажлыг хийсний үр дүнд лавлагаа мэдээллийн ач холбогдолгүй, хадгалах хугацаа дууссан, илүү хувь зэрэг 1977-2003 оны баримтаар 5 хадгаламжийн нэгжид “Устгах хэргийн акт” үйлдэж, нийт байнга хадгалах 1981-2006 оны 67 хадгаламжийн нэгж , түр хадгалах 1998-2006 оны 107 хадгаламжийн нэгж , 70 жил хадгалах цалингийн 1975-1997 оны 109 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах боловсон хүчний холбогдолтой 21 хадгаламжийн нэгж , нийт 304 хадгаламжийн нэгжийг Нийслэлийн архивын газар хүлээлгэн өгсөн болно.

Тус компанийн 2006 оны хагас жилээс 2009 оныг дуусталх хугацааны баримтыг 2010 оны 1 дүгээр улиралд өөрийн компанийн архивт хүлээн авсан.

Байгууллагын дэргэдэх ББНШК-ыг захирлын 2010 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тушаалаар комиссын даргаар менежер Ж.Цэцэгмаа, нарийн бичгийн даргаар архивын ажилтан П.Намжилмаа, гишүүн ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, эрүүл ахуйч Б.Хулан нарын 4 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллаж байна.

ББНШК-ын анхны хуралдаанаар тус комиссын ажиллах дүрэм, Архивын дүрэм, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт зэрэг асуудлыг хэлэлцсэн болно. 2011 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн 14 дүгээр тушаалаар байгууллагын нягтлан шалгах комисс байгуулагдаж архивын дүрмийг шинэчлэн боловсруулан баталсан.

Архивын ажилтан П.Намжилмаа 2006-2009 оны баримтанд Нийслэлийн архивын газрын мэргэжилтний заавар, зөвлөгөөний дагуу эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж, байнга хадгалах 2006-2009 оны 25 хадгаламжийн нэгж, түр хадгалах 2006-2009 оны 92 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах боловсон хүчний болон цалингийн холбогдолтой 8 хадгаламжийн нэгж , нийт 125 хадгаламжийн нэгжийг бүртгэж хүлээн аваад байна.

Мөн 2011 он хүртэлх байнга хадгалах 16 хадгаламжийн нэгж, түр хадгалах 44 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгж бүртгэсэн . Тус байгууллагын архивт 2006-2011 оны байнга хадгалах хадгаламжийн нэгж /Захирлын тушаал, хурлын тэмдэглэл, бизнес төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, аудитын тайлан, гэрээ/, 2006-2011 оны түр хадгалах хадгаламжийн нэгж /ирсэн, явуулсан бичиг, харилцахын баримт, кассын баримт, хүнсний материалын тайлан, цэцэрлэгээс авсан санал асуулга, шинжилгээний бичиг/, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж /цалингийн карт, боловсон хүчний холбогдолтой тушаал/ зэрэг баримтуудыг үдэж, хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэн, зориулалтын бус сейфэнд хадгалж байна.

Манай байгууллагын тухайд санхүүгийн ажилтнууд мэдээ судалгаа гаргах, аудитын байгууллагад баримт хүлээлгэн өгөх зэргээр тайлан, тэнцэл болон цалингийн холбогдолтой баримтыг архиваас түр хугацаагаар авч ашиглаж байна.

Нийслэлийн Архивын газрын сан хөмрөгт байнга хадгалагдаж байсан 67ХН-д 2012 оны 04 дүгээр сарын 18-20-ны хугацаанд Арга зүйч-Сан хөмрөгийн эрхлэгч У.Даваажав дахин боловсруулалт хийжээ. Тус ажлын хүрээнд дугааргүй баримт бичгийг дугаарлаж, хэд хэдэн оны баримтыг хамт үдсэнийг салгаж, оны дараалалд оруулсан. Мөн нүүр бичилт хийгдээгүй зарим баримтад нүүр бичилт хийжээ.

Түр хадгалах баримтаас дахин боловсруулалтаар байнга авах шаардлагатай 1999-2002 оны байгууллагын жилийн эцсийн тайлан тэнцэл, 2002 оны тооллогын бүртгэл зэрэг баримтуудыг

байнгад бүртгэж, 2006 оны Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 70 жил хадгалах баримтад шилжүүлжээ.

Нийт 79 ХН-ийн данс бүртгэлийг гарган Нийслэлийн Архивын дэргэдэх ББНШАЗК-ын 2012 оны 05 дугаар сарын 23-ны хурлаар хэлэлцүүлэн батлуулж баримтыг сан хөмрөгт хүлээлгэн өгч дансыг баталгаажуулан 1%-ийг хөмрөгт, 1%-ийг лавлагаа мэдээлэлд ашиглуулахаар лавлагаа хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгчээ.